



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Чанарын гарын авлага, удирдлагын
тогтолцооны журам батлах тухай

Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 222, 2021 оны 378 дугаар тогтоол, MNS ISO/IEC 17025:2018 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаал, Эм, эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын даргын 2022 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийг тус газарт нэгтгэсэнтэй холбогдуулан MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу Чанарын тогтолцоог сайжруулж, “Чанарын гарын авлага”-ыг нэгдүгээр, “Удирдлагын тогтолцооны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. “Чанарын гарын авлага”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм шинжлэх лаборатори (Ш.Энхзаяа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА

142022 01016